



**“УЛААНБААТАР ТЕАТР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар Б/70

Улаанбаатар хот

**Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал
олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, 2023 оны 12 дугаар сарын 442 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Улаанбаатар театр” ОНӨТҮГ-ын албан хаагчдын 2023 оны сүүлийн хагас жилийн ажлын үр дүнг тооцож, театрын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, ажлын төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ хангалттай гүйцэтгэсэн уран бүтээлчдэд үр дүнгийн урамшуулал олгох албан хаагчдын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тус тушаалын хавсралтаар баталсан албан хаагчдад олгох үр дүнгийн урамшууллын хувьд ногдох урамшуулалт цалинг зохих журмын дагуу, 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор тооцон олгохыг Нягтлан бодогч (С.Эрдэнэцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны ахлах мэргэжилтэн (Б.Түмэндэлгэр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ю.ГЭРЭЛБААТАР